

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ****Нэг. Хуулийн төсөл боловсруулах, үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 3.2.29 дэх зорилтын 3-т “Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах”-аар тусгагдсан. Энэ дагуу тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөл, дагалдах хуулийн төсөл, хэрэгцээ, шаардлагыг урьдчилсан судалгаа, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог тус тус боловсрууллаа.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийг 1998 онд, тус хуулийн шинэчилсэн найруулгыг 2006 онд тус тус батлан мөрдүүлж, хэрэгжилтийг зохион байгуулан, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны эрхзүйн харилцааг зохицуулж ирсэн. Дэлхийн улс орнуудын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн чиг хандлага, улс орны болон салбарын хөгжлийн бодлого, эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан энэхүү хуульд зарим нэмэлт, өөрчлөлтийг оруулах хэрэгцээ, шаардлага үүссэн.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагын урьдчилсан судалгааг гүйцэтгэсэн. Судалгаанд тусгагдсан санал, зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тус салбарын бодлого тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх боломжтой гэж үзэж, уг хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсрууллаа.

Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг үзэл баримтлалын хүрээнд Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, төрийн ба төрийн бус байгууллага, улсын болон хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудаас санал авч хуулийн төсөлд тусгасан. Мөн уг хуулийн төслийг улсын их хурлын цахим хуудсанд байршуулан олон нийтэд нээлттэй хэлэлцүүлж саналыг тусгасан.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд 6 хэсэг, 12 заалт нэмж, 5 хэсэг, заалтад нэмэлт оруулан, 9 хэсэг, 13 заалтыг өөрчлөн найруулж, 43 заалтад өөрчлөлт оруулан, 5 хэсэг, заалтыг хүчингүй болгон, 1 зүйлийн нэрийг өөрчилсөн бөгөөд 32 хэсэг, заалтад зөвхөн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажилтай холбогдсон нэр томъёог “судалгаа боловсруулалтын ажил” гэж өөрчлөн томъёолсноор тус хуулийн 39.4%-д нь нэмэлт, өөрчлөлт орхоор байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

- 1) Хуулийн төслийн зохицуулалт нь шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлнэ.
- 2) Шинжлэх ухаан, технологийн салбарын бодлого, удирдлагыг боловсронгуй болгох чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулна.
- 3) Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн зарим нэр томъёог шинэчлэх, нэмж тусгах, тайлбарыг нарийвчилна.
- 4) Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн эрхлэх асуудал, бүрэн эрхийн хүрээг өөрчилнө.
- 5) Шинжлэх ухаан, технологийн чиглэлийн үйл ажиллагаанд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, гадаад дотоод хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 6) Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын төсөвт тусган санхүүжүүлэх, үндсэн чиг үүргийн дагуух олсон орлогыг арилжааны банкны дансанд байршуулах захиран зарцуулах талаар зохицуулалтыг оруулна.
- 7) Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилтийн зарчмыг шинэчилж, судалгаа хөгжүүлэлтийн ажлыг санхүүжүүлэх журмыг тогтооно.
- 8) Шинжлэх ухаан, технологийн салбарын үйл ажиллагаанд оролцогчын чиг үүрэг, эрхийг тодорхой болгоно.
- 9) Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийг тогтоох зорилгоор магадлан итгэмжлэл явуулж байх, хүндэтгэн үзэх шалтгаанаар ээлжит магадлан итгэмжлэлд хугацаандаа хамрагдаж чадаагүй эрдэм шинжилгээний ажилтныг нөхөн хамруулж байх зохицуулалтыг тусгасан.
- 10) Оюуны хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, тус салбарт ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх асуудлын хүрээнд эрдэм шинжилгээний болон инженер-техникийн ажилтан, лаборант өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол ажилласан хугацааг харгалзан ажиллаж байгаа байгууллагаас нь 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгоно.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох, нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Шинжлэх ухаан, технологийн удирдлага, бүтэц тогтолцоог сайжруулах” хувилбаруудын эдийн засагт үзүүлэх үр нөлөөг дараах байдлаар тодорхойлов.

Эдийн засагт ямар нэг байдлаар үр нөлөө үзүүлэхгүй бөгөөд тодорхой нэмэлт зардал гарах боловч яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөл нь холбогдох асуудлаар зөвлөмж боловсруулахаар судалгаа шинжилгээ хийж гүйцэтгэх, уг боловсруулсан зөвлөмжийг шинжлэх ухаан технологийн үндэсний зөвлөлд хүргүүлэн үндэсний зөвлөл нь яамдаас ирсэн зөвлөмжийг нэгтгэх зэргээр үйл ажиллагааны шат дарааллыг нэмэгдүүлснээр зөвхөн захиргааны зардал нэмэгдэх ба бусад зардал их хэмжээгээр нэмэгдэхгүй тул эдийн засагт төдийлөн сөрөг үр нөлөө багатай байна. Ер нь шинжлэх ухаан, технологийн салбар оруулах хөрөнгө оруулалт, санхүүжилт нэмэгдэх боломжтой бөгөөд энэ утгаар эдийн засаг эерэг үр нөлөө үзүүлэх боломжтой байна.

Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилтийн асуудлыг зохицуулсан зохицуулалтын тодорхой болгох, эрдэм шинжилгээний байгууллагын санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор дэвшүүлсэн хувилбарын эдийн засагт үзүүлэх үр нөлөөг дараах байдлаар тодорхойлов.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд зааснаар болон төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой эрдэм шинжилгээний байгууллагын санхүүжилтийг өнөөдрийг хүртэл улсын төсвөөс санхүүжүүлж ирсэн тул уг санхүүжилтийн хэмжээг улсын эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан нэмэгдүүлэлгүйгээр үргэлжлүүлэх боломжтой юм.

Хууль тогтоомжийг боловсронгуй болгож, эрдэм шинжилгээний байгууллагын санхүүжилтийг нэмэгдүүлсэнээр нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ.

Энэхүү судалгааны тайланд дэвшүүлсэн саналуудыг хэрэгжүүлснээр байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол улсын үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, бусад хууль тогтоомжтой нийцэж байна.

Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилтийн асуудлыг зохицуулсан зохицуулалтын тодорхой болгох, эрдэм шинжилгээний байгууллагын санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор дэвшүүлсэн саналуудын хувьд эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн үйл ажиллагааны санхүүжилт буюу суурь санхүүжилтийн талаар хууль тогтоомжид тусган өгөх нь Үндсэн хууль, олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Төсвийн тухай хуульд заасанчлан улсын төсвөөс санхүүждэг байгууллагын суурь санхүүжилтийн асуудлыг зохицуулан тусгаж байгаа тул тэдгээр хууль тогтоомжид нийцэж байгаа юм. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй

холбогдуулан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулна.